



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 07 сарын 20 өдөр

Дугаар А/304

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны 05 дугаар сарын 30-ний өдрийн А/203 дугаар тушаалын Б.3, Б.4-д заасан Үндэсний шигшээ багийн тамирчдыг оношлогоо, эмчилгээ, сэргээн засах үйлчилгээнд дэмжлэг үзүүлэхэд 45,000,000 /дөчин таван сая/ төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй тамирчдын оношлогоо эмчилгээ, сэргээн засах үйлчилгээнд дэмжлэг үзүүлэхэд 45,000,000 /дөчин таван сая/ төгрөгийг зарцуулах эрхийг Биеийн тамир, спортын хөгжлийн төвд шилжүүлсүгэй.

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулан ажиллахыг Биеийн тамир, спортын хөгжлийн төв /Д.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

3. Эрх шилжүүлсэнтэй холбогдуулан ажлын гүйцэтгэл, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Стратеги бодлого төлөвлөлтийн газрын Санхүү, эдийн засгийн хэлтэс /Т.Баярсайхан/-д даалгасугай.

САЙД



С.ЛАМБАА

081135